



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 13 өдөр

Дугаар A/151

Мөрөн сум

Г Ажлын хэсэг байгуулж, хөрөнгө  
зарцуулах тухай Т

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1, 25.1.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит хуралдааны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн улсын үзлэгийг Хөвсгөл аймагт үйл ажиллагаа явуулж буй Политехникийн коллежид зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

П.Галсандорж

(Нийгмийн бодлогын хэлтсийн Боловсрол, шинжлэх ухааны бодлого, үйл ажиллагааг зохион байгуулах ахлах мэргэжилтэн)

Гишүүд: А.Цэнд-Аюуш

(Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч)

Б.Удвал

(Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч)

Н.Хонгорзул

(Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын Боловсролын хяналтын улсын байцаагч)

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга: Б.Нямдаваа

(Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдлын асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Улсын үзлэгийг 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн 04 дүгээр сарын 21-ний өдрийн дотор батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулж, тайланг аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн дотор хүргүүлж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (П. Галсандорж)-д үүрэг болгосугай.

3. Үзлэг шалгалт, удирдамжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлын 400.000 (дөрвөн зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг дарга ерөнхий дансны "Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн турван талт хамтын ажиллагаа, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр зохион байгуулах арга хэмжээний зардал"-аас гаргаж зарцуулахыг аймгийн Төсвийн ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л. Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б. Мөнгөн-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН

6710010574